

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН
ТУХАЙ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

**2014 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр**

**Улаанбаатар
 хот**

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн
Ж.Энхбаяр**

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хууль, зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгийг тус Байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хийж гаргасан санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлж байна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, С.Дэмбэрэл, Ж.Энхбаяр, Ц.Цолмон, Г.Баярсайхан нар төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж тодруулга авсан болно.

Хэлэлцүүлэгийн үеэр Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн байгаль орчны чиглэлээр гэсэн хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан “хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх, ашиглах тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор нэмэх”, мөн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах;

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл төсөлд “ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх энгийн зөвшөөрлийг сум дүүргийн засаг дарга, сум дундын болон сум дүүргийн ойн анги олгохоор нэмэх”, мөн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс “13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт” гэснийг хасах;

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг төслийн “1-05 код бүхий зөвшөөрлийг ахуйн зориулалтаар цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд аймаг нийслэлийн байгаль орчны алба” байхаар өөрчлөх, мөн төслийн “1-06 код бүхий зөвшөөрлийг газрын доорх болон гадаргын усны эх үүсвэрийг үйлдвэрийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд сав газрын захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны алба, сум дүүргийн засаг дарга олгохоор өөрчлөх;

Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн үйлдвэр хөдөө аж ахуйн чиглэлээр гэсэн хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан хэрэглээний мал амьтныг экспортлох, малын эм худалдах зөвшөөрлийг нэмэх, 9-06 код бүхий малын эмийн улсын бүртгэл гэсэн зөвшөөрлийг хасах;

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг тамхи үйлдвэрлэх зөвшөөрөл нэмэх, төслийн 9-09 код бүхий ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох үйл ажиллагаа эрхлэх гэсэн зөвшөөрлийг хасах;

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл төслийн 9-03 код бүхий зөвшөөрлийг үржлийн мал экспортлох гэж өөрчлөх;

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл төслийн барилга, хот байгуулалтын чиглэл гэсний 5-15 код бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх гэсэн зөвшөөрлийг хасах зэрэг саналуудыг тус тус гаргасныг Байнгын хороо дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг төслийн үйлдвэр хөдөө аж ахуйн чиглэлд хивэг экспортлох зөвшөөрөл нэмэх гэсэн саналыг Байнгын хороо дэмжээгүй болно.


Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Засгийн газар уг төслийг нухацтай хэлэлцээгүй боловсруулалт муутай байгааг тэмдэглэж хэлсэн бөгөөд тухайн үед нь гэрээ хэлцэлээр шийдвэрлэх боломжтой асуудлууд байгааг анхаарч төрөл бүрийн зөвшөөрөл эрх лиценц нэмэх байдлыг сайн судалж уян хатан шийдвэрлэх, хуулийн техникийн алдаа болон дагалдаж өргөн мэдүүлсэн салбарын холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын давхардал зөрчлийг хянах хэрэгтэй гэснийг Байнгын хороо дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хууль, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Түүхнээс хүслэ.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.БАЯРСАЙХАН



**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТУХАЙ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг: Байнгын хороо дэмжсэн

1.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Байгаль орчны чиглэлээр” гэсэн хэсэгт “1-16 гэсэн код бүхий Хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага” гэж нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

2.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн гарчийн, “нэвтрүүлэх” гэсний дараа “ашиглах” гэж тус тус нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

3.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн зөвшөөрөл авах хүсэлтдээ” гэсний дараа “ Зөвшөөрлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т зааснаас гадна” гэж нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

4.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалт, 6.6 дахь хэсгийг тус тус хасах ” гэсэн зүйл нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

5.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай төслийн 1 дүгээр зүйлийн “Байгаль орчны чиглэлээр” гэсэн хэсэгт “1-17 гэсэн код бүхий Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд Сум дүүргийн засаг дарга, сүм дундын болон сүм, дүүргийн ойн анги” гэж нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл

6.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлээс 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтыг хасах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл

7.Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн

“Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсгийн 9-03 код бүхий зөвшөөрлийг
“Үржлийн мал экспортлох” гэж өөрчилж зөвшөөрлийн төрлийг тусгай болгох;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл

8. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Байгаль орчны чиглэлээр” гэсэн хэсгийн 1-05 гэсэн код бүхий зөвшөөрлийг “Ахуйн зориулалтаар цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах” зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд “Аймаг, нийслэлийн байгаль орчны алба” гэж өөрчлөн найруулах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг

9. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Байгаль орчны чиглэлээр” гэсэн хэсгийн 1-06 гэсэн код бүхий зөвшөөрлийг “Газрын доорх болон гадаргын усны эх үүсвэрийг үйлдвэрийн зориулалтаар ашиглах” зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд Сав газрын захиргаа, Аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум дүүргийн засаг дарга” гэж өөрчлөн найруулах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг

10. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Барилга, хот байгуулалтын чиглэлээр” гэсэн хэсгийн 5-15 гэсэн код бүхий “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх” гэснийг хасах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

11. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсгийн 9-03 код бүхий зөвшөөрлийн дараа “Хэрэглээний мал амьтныг экспортлох” гэж нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

12. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсгийн 9-05 код бүхий зөвшөөрлийн дараа “Малын эм худалдах” гэж нэмэх;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

13. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсгийн 9-06 код бүхий “Малын эмийн улсын бүртгэл” гэснийг хасах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

14. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсгийн 9-09 код бүхий “Ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох үйл ажиллагаа эрхлэх” гэснийг хасаж “Тамхи үйлдвэрлэх” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг

Хоёр: Байнгын хороо дэмжээгүй

1. Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн
“Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр” гэсэн хэсэгт “Хивэг экспортлох” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО